

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2025 оны 12 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСАГ 2024 ОНД

ДНБ-ий өсөлт

(2024 он)

5.1 хувь

Гадаад валютын нөөц

(2024 оны эцэс)

5.5 тэрбум \$

Инфляц

(2024 оны 12 дугаар сар)

9.0 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2024 оны эцэс)

-776 тэрбум ₮

Экспорт

(2024 оны эцэс)

15.8 тэрбум \$

Импорт

(2024 оны эцэс)

11.6 тэрбум \$

ГШХО

(2024 он)

4.2 тэрбум \$

Зээлийн хүү

(2024 оны 12 дугаар сар)

16.9 хувь

Ажилчдын тоо

(2024 он)

1.36 сая

*2024 оны байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 61.3 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2024 он)

2.9 хувь

*ХҮИ 2020=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны эцэс)

108.4 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2024 он)

9.0 хувь

ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2025.12

ДНБ-ий өсөлт

(2025 оны 3 дугаар улирал)

5.9 хувь

Гадаад валютын нөөц

(2025 он)

7,005 сая \$

Инфляц

(2025 оны 12 дугаар сар)

7.5 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 12 дугаар сар)

-1,232 тэрбум ₮

Экспорт

(2025 он)

15.7 тэрбум \$

Импорт

(2025 он)

11.3 тэрбум \$

ГШХО

(2025 оны 2 дугаар улирал)

1.4 тэрбум \$

Зээлийн хүү

(2025 оны 12 дугаар сар)

17.2 хувь

Ажилчдын тоо

(2025 оны 3 дугаар улирал)

1.39 сая

*III улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.7 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2025 оны 3 дугаар улирал)

1 хувь

*ХҮИ 2020=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2025 оны 3 дугаар улирал)

115.0 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 3 дугаар улирал)

4.0 хувь

2025 оны 3 дугаар улирал



- ХАА-н салбар 2025 оны 3 дугаар улиралд жилд 33.8 хувиар өслөө.
- Цаг агаарын нөхцөл байдал хэвийн байж, бойжсон төлийн тоо толгой 21.1 саяд хүрч (төл бойжилт 98.4 хувь) өмнөх оны мөн үеэс 5.6 сая толгой малаар нэмэгдэн, тоо малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс 7.9 сая толгой малаар буурсны голлох нөлөөгөөр сүүлийн хоёр жил дараалан буурсан хөдөө аж ахуйн салбар сэргэв.



Эрэлт талаас өсөлтийг өрхийн хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал болон үйлчилгээний экспорт дэмжлээ.

ДНБ-ий өсөлт
(жилийн өсөлтийн хувь)



- Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 7.4 нэгж хувийг өрхийн хэрэглээ, 6.5 нэгж хувийг үндсэн хөрөнгийн хуримтлал, 1.3 нэгж хувийг цэвэр экспорт бүрдүүлсэн байна.
- Харин эргэлтийн хөрөнгийн бууралт өсөлтийг 9.1 нэгж хувиар, төрийн хэрэглээ 0.2 нэгж хувиар бууруулсан байна.

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН
ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)




- Төрийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар буурсан бол өрхийн хэрэглээний өмнөх улирлын өсөлт хадгалагдаж, 9.7 хувиар нэмэгдлээ.

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН
ӨСӨЛТ (жилийн өсөлтийн хувь)



- Үндсэн хөрөнгийн хуримтлал 18.8 хувиар өсөхөд орон сууцны бус барилга байгууламжийн нөөц бодитоор 30.1 хувиар, орон сууцны барилга 22.8 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөллөө. Мөн өмнөх онд бууралттай байсан биологийн өсөж үрждэг хөрөнгө өсөлттэй гарч хөрөнгийн хуримтлалыг нэмэгдүүллээ.


ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(жилийн өсөлтийн хувь)




- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 2.4 хувиар өссөн бол бараа, үйлчилгээний импортын өсөлт үргэлжлэн саарч 0.3 хувь болсон нь цэвэр экспортод эерэг нөлөө үзүүлж байна.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 онд 4.8 хувиар өслөө. Уул уурхайн салбарт зэс, төмрийн хүдрийн олборлолтын биет хэмжээ болон үнэ өссөн нь голлон нөлөөлөв.



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 онд 52.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.8 хувиар өслөө.
- Газрын тос болон уул уурхайн туслах үйл ажиллагааны үйлдвэрлэл буурсан ч зэсийн баяжмалын үйлдвэрлэл өссөнөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 2.2 хувиар өслөө.
- Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл (нэрлэсэн дүнгээр) 2025 онд 12 хувиар өсөхөд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон төмөрлөг бус эрдэс бодисын үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлөв.



- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 70 орчим хувийг* уул уурхайн салбар, түүний дотор 43 хувийг нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2025 онд 95.5 сая тонн болж, өмнөх оноос 0.4 хувиар өслөө. Мөн 2025 оны 12 дугаар сарын байдлаар нүүрс олборлолт өмнөх оны мөн үеэс 25.7 хувиар өссөн байна.

*2024 оны байдлаар

УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

(голлох бүтээгдэхүүнээр)

		өмнөх оноос өөрчлөлт:
Зэсийн баяжмал	2,127 мян.тонн	36.2%
Газрын тос	3.8 сая баррель	-10.0%
Алт	13.1 тонн	4.1%
Төмрийн хүдэр	12.9 сая.тонн	27.9%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2025 онд нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 36.2 хувиар өсөж 2,127 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 12.9 сая тоннд хүрч, 27.9 хувиар өссөн байна.
- Мөн алт олборлолт 4 хувиар өссөн бол газрын тос олборлолт өмнөх оны үйлдвэрлэлийн түвшнээс 10 хувиар буурсан байна.




- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2025 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өссөн байна.
- Үнэ өссөн:
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8.4 хувиар;
 - Ундаа үйлдвэрлэл 19.1 хувиар;
 - Металлын хүдэр олборлолт 43 хувиар;
 - Цахилгаан, хий, уур, агааржуулалт 37.3 хувиар
- Үнэ буурсан:
- Нүүрс олборлолт 30.4 хувиар;
 - Газрын тос олборлолт 18.7 хувиар.

1.4 БОЛОВСРУУЛАХ САЛБАР – Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн


2025 онд




Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2025 онд бодит дүнгээр 4.8 хувиар өсөв. Үүнд төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл, мах боловсруулах, консервлох, металл үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөллөө.




- Боловсруулсан малын мах 2025 онд 61.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 6 хувиар өслөө.
- Боловсруулсан махны биет хэмжээ өсөхөд үхэр, адууны махны боловсруулалт нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Мөн боловсруулах салбарын 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 20.6 хувиар өслөө.



- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 онд 170.3 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар өссөн байна.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ нэмэгдэж боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг гурил болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл бодит дүнгээр (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 7.5 хувиар өслөө.




- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 онд 562.9 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөн ч боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 3.6 хувиар буурлаа.




- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2025 онд 4 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 543 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээ нэмэгдэж боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 10.2 хувиар өндөр байна.




Барилгын салбарын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент, вакум цонх болон хаалганы үйлдвэрлэл нэмэгдэж, металл бэлдэц болон цувимлын үйлдвэрлэл бууралттай хэвээр байна.



■ Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 онд 2,166 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар өссөн байна.



■ Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 онд 7.6 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 8.9 хувиар өслөө.



■ Металл бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 онд 69.2 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар доогуур байна.



■ Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 онд 47.4 мянган м.кв болж, өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар өслөө.



Нүүрсний тээвэр сэргэснээр төмөр замын ачаа тээвэр эхний 12 сард өмнөх оны мөн үеэс 5.8 хувиар өслөө. Инфляцын нөлөөгөөр худалдаа, нийтийн хоолны салбарын бодит орлого буурсан үзүүлэлттэй байна.



- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний 11 сард нэрлэсэн дүнгээр 60.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 хувиар өссөн бол үнийн нөлөөг засварласан бодит дүнгээр 5.2 хувиар буурсан байна.



- 2025 оны эхний 11 сард нэрлэсэн дүнгээр зочид буудлын салбарын борлуулалтын орлого 16.7 хувиар өссөн бол нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 11.6 хувиар өссөн байна.
- Үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлого 1.0 хувиар өссөн бол нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 3.4 хувиар буурсан байна.



- Төмөр замаар 2025 оны эхний 11 сард 44.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.8 хувийн өсөлттэй байна.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 20.1 хувийн өсөлттэй байна.
- Экспортын нүүрс тээврийн зай буурснаас үүдэн авто замаар 2025 оны эхний 3 улиралд 67.1 сая тонн ачаа тээвэрлэв.



- 2025 оны эхний 12 сарын байдлаар Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 847.2 мянгад хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.5 хувиар өссөн байна. 2025 онд хүлээн авсан жуулчдын тоо нь мөн үед хүлээн авсан жуулчдын түүхэн дээд хэмжээ юм.

1.7 ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)

2025 оны 3 дугаар улирал


Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг илэрхийлдэг худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны 3 дугаар улиралд 45.4 хувь болж, бизнесүүд эдийн засаг агшина гэсэн хүлээлттэй байна.

PMI
(50=өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

PMI, гол салбараар
(50=өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

PMI, аж ахуйн нэгжийн төрлөөр
(50=өөрчлөлтгүй)



Эх сурвалж: Монголбанк

PMI, үзүүлэлтүүдээр
(50=өөрчлөлтгүй)



Эх сурвалж: Монголбанк

- Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг хэмждэг Худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны 3 дугаар улиралд 45.4 хувь болж, өмнөх улирлаас 0.1 нэгж хувиар сайжирсан бол өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар доогуур гарлаа.


- Барилгын салбарын PMI өмнөх улирлаас 3.1 хувиар буурч, 37.6 хувь болж, сөрөг хүлээлттэй хэвээр байна.
- Аж үйлдвэрийн салбарын PMI өмнөх улирлаас 3.1 нэгж хувиар саарч, тус салбарын бизнес эрхлэгчид 3 улирал дараалан сөрөг хүлээлтэй байна.
- Харин үйлчилгээний салбарын PMI өмнөх улирлаас 6.5 нэгж хувиар сайжирсан ч 3 улирал дараалан, худалдааны салбар 4 улирал дараалан сөрөг хүлээлттэй байна.

- 2.5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалттай том аж ахуйн нэгжүүдийн PMI өмнөх улирлаас 1.2 нэгж хувиар сайжирсан ч 3 улирал дараалан агшилтын мужид байна.
- Харин 1-2.5 тэрбум төгрөгийн борлуулалттай дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдийн PMI өмнөх улирлаас 9.2 нэгжээр огцом буурч, 4 улирал дараалан сөрөг төлөвт байна.
- 1 тэрбум төгрөгөөс бага борлуулалттай жижиг бизнесүүдийн PMI 36.7 хувь болж, тогтмол сөрөг хүлээлттэй байна.


- Бизнесийн гол үзүүлэлтүүд 2025 оны 3 дугаар улиралд бүгд буурах хүлээлттэй гарлаа.




2025 оны байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 27.0 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.



- Экспорт 2025 онд 15,701 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурлаа.
- Нийт экспортын 93 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлээ.



- Нүүрсний экспортын орлого 5,769 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 34 хувиар буурлаа.
- Зэсийн баяжмалын экспортын орлого 5,809 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 75 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 1,241 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 38 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 634 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар өслөө.



- 2025 онд импорт 11,312 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар буурсан байна.
- Нийт импортын 20.2 хувийг тоног төхөөрөмж, 17.1 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 12.8 хувийг барилгын материал, 10.7 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 8.8 хувийг суудлын автомашин эзэлж байна.
- Ачааны тээврийн хэрэгслийн импорт 30.1 хувиар, авто бензиний импорт 6.4 хувиар, суудлын автомашины импорт 5.5 хувиар буурсан нь нийт импорт буурахад нөлөөллөө.




- Нефтийн бүтээгдэхүүний импорт 1,939 сая ам.долларт хүрч, өмнөх оны түвшинд байна.
- Тоног төхөөрөмжийн импорт 2,297 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 1,003 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар буурлаа.
- Барилгын материалын импорт 1,452 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өслөө.
- Хүнсний импорт 1,217 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өслөө.

2.2 УУЛ УУРХАЙН ЭКСПОРТ


2025 он




2025 онд уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 93 хувийг бүрдүүллээ.




- Нүүрсний экспортын биет хэмжээ 2025 онд 90.0 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өслөө.



- Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 2025 онд 2,282 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 34.6 хувиар өслөө.



- Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2025 онд 8,800 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 17.5 хувиар өслөө.




- Газрын тосны экспортын биет хэмжээ 2025 онд 3,523 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар буурлаа.


2.3 ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭКСПОРТ

2025 онд хөдөө аж ахуйн экспорт өмнөх оноос 9 хувиар нэмэгдлээ.


ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ
ЭКСПОРТ
(сая ам.доллар)




ХОНЬ ЯМААНЫ МАХ
(сая ам.доллар)




САМНАСАН НООЛУУР
(сая ам.доллар)



АРЬС ШИР
(сая ам.доллар)




БОЛОВСРУУЛСАН МАХ
(сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

АДУУ, ҮХРИЙН МАХ
(сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

УГААСАН НООЛУУР
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС
(сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ
ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС
(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн
сайн чанарын коксжих нүүрс)



- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2025 оны 12 дугаар сарын дундаж үнэ 224 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 15 хувиар өссөн байна.

ЗЭС
(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)




- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2025 оны 12 дугаар сарын дунджаар 13056 ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 45 хувиар өссөн байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ
(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн
агууламжтай төмрийн баяжмал)



- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2025 оны 12 дугаар дундаж үнэ 109 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 8 хувиар буурсан байна.

ГАЗРЫН ТОС
(\$/баррель, Брент)



- Брент газрын тосны 2025 оны 12 дугаар сарын дундаж үнэ 62 ам.долларт өмнөх оны мөн үеэс 13 хувиар буурсан байна.


4. УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА

2025.12 сар



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний 12 сард 21.8 сая тонн нүүрс, 5.9 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 51.5 мянган тонн жоншны баяжмал, 45.3 мянган тонн зэсийн баяжмал арилжаалаад байна.


НҮҮРСНИЙ АРИЛЖАА (сая тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2025 оны 12 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 59.1 сая тонн нүүрс арилжиж, 6.1 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд 22.4 сая тонн нүүрс арилжиж, 2.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 12 сард 21.8 сая тонн нүүрс борлууллаа.


НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ (ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2025 оны 12 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 86 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 83 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 12 дугаар сард хэлцлийн доод үнэ 20 ам.доллар, дээд үнэ 134 ам.долларт хүрэв.

ТӨМРИЙН АРИЛЖАА (мянган тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2025 оны 12 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 9.0 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 602 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2024 онд 2.4 сая тонн төмрийг арилжаалж, 167 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 12 сард 5.9 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ (ам.доллар/тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж


- Төмрийн хүдэр болон баяжмалын 12 дугаар сарын дуудах дундаж үнэ 65 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 72 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 12 дугаар сард хэлцлийн доод үнэ 64 ам.доллар, дээд үнэ 86 ам.долларт хүрэв.




Төлбөрийн тэнцэл 2025 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар 63 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны эцэст өмнөх оноос 1.5 сая ам.доллараар өсөж, 7.0 тэрбум ам.долларт хүрлээ.




- Төлбөрийн тэнцэл 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 63 сая ам.долларын ашигтай байна.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал дансны алдагдал 720 сая ам.доллараар бага бол, санхүүгийн дансны ашиг 856 сая ам.доллараар их байна.



- Гадаад валютын улсын нөөц 2025 оны 12 дугаар сарын эцэст 7,005 сая ам.доллар болж, өмнөх сараас 1,119 сая ам.доллар, өмнөх оны мөн үеэс 1,495 сая ам.доллараар тус тус өслөө.



- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 12 дүгээр сард өдөрт дунджаар 0.1 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,557 төгрөгт хүрлээ.



- Төв банк 2025 оны 12 дугаар сард нийт 650 сая ам.долларыг зах зээлд нийлүүллээ.
- Төв банк 2025 онд өмнөх оны мөн үеэс 623 сая ам.доллараар бага буюу 5.9 тэрбум ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлээд байна.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон эзэлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн




Инфляц 2025 оны 12 дугаар сард 7.5 хувьд хүрч, өмнөх сараас 0.7 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх сараас 0.7 нэгж хувиар буурахад хүнс, түрээс болон суудлын машины үнийн өсөлт саарсан нь нөлөөлсөн байна.



- Инфляц 2025 оны 12 дугаар сард улсын хэмжээнд 7.5 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.0 нэгж хувь (26.8 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 5.5 нэгж хувь буюу 73.2 хувийг эзэлж байна.



- 2025 оны 12 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.6 хувиар өслөө.
- Сарын инфляц 0.6 хувь гарахад махны үнэ 2.4 хувиар, сүүний үнэ 9.3 хувиар, хүнсний ногооны үнэ 4.1 хувиар, хувцас, бөс бараа, гутлын үнэ 0.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2025 оны 12 дугаар сард суурь инфляц 6.7 хувь гарч, нийт инфляцын 4.1 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн сар буурлаа.



- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт эрчимжсэнээр жилийн инфляцын 21.3 хувийг бүрдүүллээ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар өслөө.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 15.8 хувиар өслөө.



Олон улсад чингэлэг тээврийн үнэ 2,212 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 36 хувиар буурлаа. Хүнсний үнийн индекс 2025 оны 12 дугаар сард өмнөх сараас 0.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Хүнсний инфляц 2025 оны 12 дугаар сард 11.3 хувь болж, нийт инфляцын 3.0 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц эрчимжихэд мах, гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлт нөлөөллөө.
- Хүнсний бус инфляц 6.1 хувь болж, нийт инфляцын 4.5 нэгж хувийг бүрдүүллээ.




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 12 дугаар сард дунджаар 3,549 төгрөг болж, өмнөх сараас 0.6 хувиар чангарлаа.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2025 оны 12 дугаар сард өмнөх сараас 0.1 хувиар өслөө.



Эх сурвалж: Drewry World Container Index

- АНУ-ын тарифын бодлогоос үүдэлтэйгээр дэлхийн чингэлэг тээврийн үнэ өсөөд байсан бол 2025 оны 6 дугаар сараас эхлэн аажмаар буурч эхэллээ.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2026 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 2,212 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 36 хувиар буурсан байна.
- Чингэлэг тээврийн үнэ буурч байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг бууруулж байна.




Эх сурвалж: FAO

- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2025 оны 12 дугаар сард 124.3 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 хувиар, өмнөх сараас 0.6 хувиар тус тус буурсан байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр үр тариа, элсэн чихрийн үнэ өссөн бол сүүн бүтээгдэхүүн, мах, болон ургамлын тосны үнэ буурсан байна.




Нэгдсэн төсвийн тэнцэл 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Үүнд нүүрсний үнэ болон экспортын орлогын бууралтаас шалтгаалан төсвийн орлого төвлөрүүлэлт саарсан нь голлон нөлөөллөө.

ТӨСВИЙН ОРЛОГО
(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)




- Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны 12 дугаар сарын байдлаар 30.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 923.7 тэрбум төгрөг буюу 1.6 хувиар өссөн байна.
- Төсвийн орлогын өсөлтөд НД-ын орлого 924.0 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оноос 19.7 хувиар, ХХОАТ 323.2 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар, нийтлэг татварын бус орлого 852.3 тэрбум төгрөг буюу 48.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ТӨСВИЙН ЗАРЛАГА
(зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



- Төсвийн зарлага 2025 оны 12 дугаар сард 31.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 923.7 тэрбум төгрөг буюу 3.0 хувиар өссөн байна.
- Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг 2025.01.01-ний өдрөөс өмнөх оны инфляцын түвшинд уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлсэн.
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 6.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар, тэтгэвэр, тэтгэмж 8.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар тус тус өссөн байна.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ
(их наяд төгрөг)



- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны 12 дугаар сарын байдлаар 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад нүүрсний үнийн бууралттай холбоотойгоор АМНАТ болон ААНОАТ-ын орлого буурснаар төсвийн орлого төвлөрүүлэлт саарсан нь голлох нөлөө үзүүлээ.


ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)
(Зүүн тэнхлэг: их наяд төгрөг
Баруун тэнхлэг: ДНБ-д эзлэх хувь)



- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны гуравдугаар улиралд 35.7 их наяд төгрөг буюу ДНБ-д эзлэх хувь 39.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 15.9 хувиар өссөн байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 12 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өсөж, 47.1 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 12 дугаар сард 43.8 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 19.0 хувьд хүрлээ.



- Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 12 дугаар сарын эцэст 47.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 9.4 нэгж хувь, гадаад валютын хадгаламж ба харилцах 2.3 нэгж хувь, төгрөгийн харилцах -1.1 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.



- Нийт хадгаламж 31.8 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 18.3 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 26.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.3 хувиар, өмнөх сараас 5.5 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 5.7 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 18.2 хувиар, өмнөх сараас 6.1 хувиар тус тус өслөө.




- Банкнудын зээлийн үлдэгдэл 2025 оны 12 дугаар сарын эцэст 43.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.1 хувь буюу өмнөх оны мөн үеэс өөрчлөлтгүй байна.



- Банкнудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 12 дугаар сард 17.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өссөн бол өмнөх сараас 0.2 нэгж хувиар буурсан байна.
- Банкнудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 12 дугаар сард 12.0 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар, өмнөх сараас 0.3 нэгж хувиар тус тус өсжээ.



Ажиллагчдын тоо 1 сая 394 мянгад хүрсэн ч өсөлтийн хурд саарч, ажилгүй иргэдийн бууралтын нөлөөгөөр ажиллах хүчний өсөлт удааширч, ажиллах хүчний оролцооны түвшин 62.7 хувь болж буурлаа.




- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 33 мянга буюу 2.5 хувиар нэмэгдэж 1 сая 394 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 238 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2025 оны 3 дугаар улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 25 мянгаар, эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 8 мянгаар тус тус өссөн байна.
- Ажиллагчдын тооны өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлтийн нөлөөгөөр ажиллагчдын тоо 21 мянгаар нэмэгдсэн мөн уул уурхай салбарын ажиллагчид 20 мянгаар нэмэгдэж түүхэн дээд түвшиндээ хүрч өссөн нь голчлон нөлөөлжээ. Түүнчлэн барилга, боловсруулах салбарын ажиллагчид нэмэгдсэн нь нийт ажиллагчдын өсөлтийг дэмжсэн байна.
- Харин тээвэр, цахилгаан ус, худалдаа, үйлчилгээний салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.
- Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 7.5 мянгаар буурснаар ажилгүйдлийн түвшин 5.5 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурсан байна.
- Харин ажиллах хүчний оролцооны түвшин ажилгүй иргэдийн буурсан нөлөөгөөр өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурч 62.7 хувьд хүрээд байна.
- Дундаж цалингийн хэмжээ 2025 оны III улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 10 хувиар өсөж, 2 сая 714 мянган төгрөгт хүрлээ.
- Улсын голч цалин 288 мянган төгрөгөөр буюу 14 хувиар өсөж, 2 сая 312 мянган төгрөг (дундаж цалингаас 402 мянган төгрөгөөр бага) болов. Энэ нь ажилчдын талаас илүү нь 2.3 сая төгрөгөөс бага цалин авч байгааг илэрхийлж байна.
- Хэрэглээний үнийн индексээр засварлагдсан бодит цалин өмнөх оны мөн үеэс 1 хувиар өсөж 1 сая 706 мянган төгрөгт хүрлээ.




Өрхийн бодит орлогын өсөлт саарч, 4.0 хувь боллоо.


ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ
(хувь)




ӨРХИЙН НЭРЛЭСЭН ОРЛОГО, ЗАРЛАГА
БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ
(хувь)



ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО
(сая төгрөг)



ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ
(хувь)



- Өрхийн бодит орлого 4.0 хувь болж, саарлаа.
- Бодит орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс нэрлэсэн дүнгээр 251.8 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 30.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.
- Өрхийн зарлагын өсөлт орлогын өсөлтийг давж, иргэдийн хадгаламжийн өсөлт үргэлжлэн удааширсаар байна.
- Бага орлоготой өрхийн орлого төдийлөн өсөлтгүй хэвээр байна.
- Нийт өрхийн 28.8 хувийг бүрдүүлж буй 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүдийн сарын дундаж нэрлэсэн орлого 949 мянган төгрөг буюу өмнөх улирлаас 45 мянган төгрөгөөр буурсан бол 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3.4 сая төгрөг болж, өмнөх улирлынхаас 164 мянган төгрөгөөр өссөн байна.
- Хөдөөгийн өрхийн бодит орлого Улаанбаатар болон улсын дунджаас өндөр байгаа ч өмнөх улирлынхаасаа 4 нэгж хувиар буурсан байна.
- Үүнд 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хөдөө суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ.



Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 4 дүгээр улиралд 263.4 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 583 мянгаар буюу 0.2 хувиар буурлаа.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО
(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 4 дугаар улиралд 263.4 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 583 мянгаар буурлаа.
- Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-үүд өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар нэмэгдсэн бол, үйл ажиллагаа зогсоосон болон олдохгүй байгаа аж ахуйн нэгжүүд 10.9 хувиар буурсан байна.
- Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо буурсан хэдий ч идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж буй нь эдийн засгийн идэвхжилттэй байгааг харуулж байна.


ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ
(ААН-ийн тоо, салбараар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо худалдааны салбарт 2.3 мянга, үйлчилгээний салбарт 2.3 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 18 хувиар өссөн байна.


ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО
(мянга, ажиллагчдын тоогоор)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйл ажиллагаа явуулж буй 116.8 мянган ААН-ийн 101.4 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өсөлтийн 102.9 хувийг бүрдүүлж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС
(улирлаар, 2018=100)



Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК)

- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2025 оны 3 дугаар улиралд 98.4 болж өмнөх оны мөн үеэс 14.3 нэгжээр муудлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 2.0 нэгжээр буурсан.
- Мөн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 19.1 нэгжээр буурсан бөгөөд үүнд бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлт муудсан нь нөлөөллөө.




ОХУ-ын эдийн засаг 2025 оны 3 дугаар улиралд 0.6 хувиар өслөө. Инфляцын түвшин 2025 онд 8.7 хувьд хүрч, өмнөх оноос 0.3 нэгж хувиар өслөө.




- ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны 3 дугаар улиралд 0.6 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар буурлаа.



- 2025 оны 11 дүгээр сарын байдлаар экспорт 32.9 тэрбум ам.доллар, импорт 26.1 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 6.8 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2025 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар буурлаа.
- Импорт 2025 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар буурлаа.




- ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.
- Инфляцын түвшин 2025 оны 12 дугаар сард 5.6 хувь болж, өмнөх сараас 1.0 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 3.9 нэгж хувиар буурсан байна.
- Жилийн инфляцын түвшин 2025 онд 8.7 хувьд хүрч, өмнөх оноос 0.3 нэгж хувиар өслөө.
- ОХУ-ын төв банкнаас 12 дугаар сарын 19-ний өдөр бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж, 16.0 хувьд хүргэх шийдвэр гаргасан.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2025 оны 12 дугаар сард 48.1 болж, өмнөх сараас 0.2 нэгжээр буурлаа.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 4.1 хувь болж, өмнөх сараас 1.0 нэгж хувиар өслөө.



Хэдийгээр дотоод эрэлт сул хэвээр байгаа ч экспорт, дотоодын эрэлт нэмэгдсэнээр БНХАУ-ын эдийн засаг 2025 онд 5.0 хувиар өслөө.




- БНХАУ-ын эдийн засаг 2025 онд 5.0 хувиар өслөө.
- 2025 оны 12 дүгээр сард экспорт 6.6 хувиар, импорт 5.7 хувиар тус тус өсөж өмнөх сараас чангарсан үзүүлэлттэй байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.




- Аж үйлдвэрийн гарц 2025 оны 12 дугаар сард 5.2 хувиар өсөж, өмнөх сараас өсөлт саарлаа.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны борлуулалт 2025 оны 12 дугаар сард 0.9 хувь болж саарсан байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.



- Хэрэглээний үнийн индекс 2025 оны 12 дугаар сард 0.8 хувь гарч дефляцийн бүсээс гарлаа.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2025 оны 12 дугаар сард -2.1 хувь гарч, үнийн уналт өмнөх сараас эрчимжлээ.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2025 оны 12 дугаар сард 50.1 болж, агшилтыг илэрхийлсэн хэвээр байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас өсөж, 50 түвшинд байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжилийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ